

**Монгол улсын татварын албаны
бүтэц, татварын улсын
байцаагчдын ёс зүйг сайжруулах
НЬ:**

2010 он


Удиртгал

1. Япон улсын татварын байгууллагын онцлог шинж чанар
2. Монгол Япон улсын татварын албаны бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны ялгаа.
3. Монгол улсын татварын албаны үйл ажиллагааны ололт, дутагдалтай талууд.
4. Дүгнэлт. Татварын албаны үйл ажиллагааг сайжруулах арга зам.


Илтгэгч: Олон улсын эдийн засаг бизнесийн дээд сургуулийн Гааль татварын 4-2 ангийн оюутан Н.Содномдаржаа

Нэг .Японы Татварын албаны удирдлагын ерөнхий онол.


Япон улсын Үндэсний татварын ерөнхий газрын бүтэц



Япон улсын бүс нутгийн татварын газрын бүтэц



Япон улсын Дүүргийн татварын хэлтсийн бүтэц



Япон улсын Татварын хяналт шалгалт

- Хувь хүнд – татварын хэлтэс, бүс нутгийн татварын газар
- ААН-д – жижиг дунд ААН-дэд татварын хэлтсээр, том хэмжээний ААН-дэд бүс нутгийн татварын газар

Япон улсын Татварын удирдлагын онцлог шинж чанар.

- 1 Олон нийтийн харилцаа татварын боловсролд ихээхэн анхаарч, Татварын зөвөлгөө өгөх ажлыг тоймжуулсан, татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч татварын тайлан гаргаж хэвшсэн.
2. Хяналт шалаглтын шатанд заавар зөвөлгөөг нилээд сайн өгдөг.
3. Татварын орлогыг төвлөрүүлэхэд хураалтын үйл ажиллагаа боловсронгуй болсон.
4. Татвар төлөгчдийн эрхийг хамгаалах арга хэмжээ хуульчлагдсан.
5. Ажилчдын давтан сургалт үр дүнтэй явагддаг.
6. Хүний нөөцийн удирдлагын хувьд туршлагатай ажилтнууд ихээхэн хувийг эзэлдэг байна.

Япон улсын олон нийттэй харилцах татварын боловсролын хандлага нь:

- Татвар төлөгчдийн ухамсрыг нэмэгдүүлэх
- Олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, мэдээллээр хангах

- Хоёр талын ойлголцол итгэлцлийг нэмэгдүүлэхэд чиглэгдэн дараахь байдлаар хийгддэг.

-Материал: Товхимол, видео бичлэг, зурагт хуудас гэх мэт

-Хэвлэл мэдээллийн хэрэгсэл: Зурагт, радио, хэвлэлийн клуб, вэб хуудас г.мэт

-Олон нийтийн боловсрол: Сургуулийн хүүхдүүд, багш нарт хичээл заах

-Олон нийтийн мэдээ: Татвар төлөгчдөд зориулсан радио суваг г.мэт

■ E-татварын систем: Татварын тухай бодъё 7 хоног

Татварын зөвлөгөө (Татвар төлөгчдөд өгөх татварын зөвлөгөөг хялбар ойлгомжтой байдлаар өгөхөд ихээхэн анхаардаг)

- Бүс нутгийн татварын газрын үтсаар зөвлөгөө өгөх төв: Улсын хэмжээнд 670 татварын зөвлөгч ажилладаг
- Эцсийн тайланг өгөх үйлчилгээ: Хувь хүний эцсийн тайлан өгөх улиралд зөвлөгөө, үйлчилгээ өгөх үйлчилгээний төв ажилладаг
- Татварын хариулт: Интернет, утас, факсын автомат хариулагчийн систем
- ҮТЕГ-ын вэб сайт: Автоматаар эцсийн тайланг бэлтгэх, тооцоолоход туслах систем
- e-татварын систем: Электрон байдлаар тайлан өгөх ба төлбөр төлөх систем

Хүний нөөцийн удирдлага

- Тухайн ажлын байранд олон жил ажиллуулдаггүй, сэлгэж байдаг
- Байнгын боловсон хүчний шинэчлэл
- Татварын байцаагч нь ердийн төрийн ажилтнаас 10 хувь илүү цалинтай, цалингийн хэмжээ өндөр.
- Тэтгэвэрт гарсны дараа татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн эрхийг өгч баталгаатай ажлын байртай болно г.мэтээр дэмждэг.

Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч ажилладаг нь татварын албанд ихээхэн тус дэм болж хамтран ажилладаг байна.

- Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн “Бие даасан” хуулиар “*Биеэ даасан, үнэн шударга байр сууринаас татварын хуульд заасан “өөрөө татвараа тайлагнах” систем болон татварын хуульд нийцүүлэн татвар төлөгчдийн итгэлийг дээшлүүлэх үүрэгтэй*” гэж заасан байна
- Татварын төлөөлөгч болж, татварын бичиг баримтыг бэлдэх, татварын зөвлөгөө өгөх г.мэт үйлчилгээ үзүүлдэг. (итгэмжлэгдсэн ня-богоос өөр хүн бусдын татварын тайланг бэлтгэж болохгүй гэж хуульд заасан)

- Японд одоо 1400 ААН-д 70,000 орчим Итгэмжлэгдсэн ня-бо ажиллаж байгаа бөгөөд Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн шалгалт авч эрх олгодог байна.
- Хуульд зааснаар татвараас зайлсхийх зөвөлгөө өгөхийг хориглодог бөгөөд хуулиа зөрчвөл ҮТЕГ-аас шийтгэлийн арга хэмжээ авч эрхийг нь хураадаг байна.

Дотоод хяналтын байцаагчдын үүргүүд.

- ҮТА-ны ажилчид ажил үүргээ гүйцэтгэх явцад гэмт хэргийн чанартай үйлдэл хийснийг шалгах , зөрчлөөс урьдчилан сэргийлэх
- Татварын албаныхны зөрчилтэй үйл ажиллагааг шалгаж, нуугдмал байдлыг илрүүлэх, засаж залруулахад анхаардаг байна.

.Татварын албаны үйлчилгээний дэг журам

- Хуулиуд болон дарга нарын зааврыг мөрдөх
- Татвар төлөгчдийн нууцыг хадгалах
- Өөрийгөө ажилдаа зориулах үүрэгтэй

Татварын ажилтнуудад хориглох заалтууд:

- Нэмэлт ажил эрхлэх
- Улс төрийн үйл ажиллагаанд оролцох
- Хориотой зан авир гаргах
 - Хахууль авах
 - Ажилтны ёс зүйн дүрэм зөрчих

Хоёр. Япон улсын Татварын албаны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны ялгаа, давуу тал.

- Япон улс нь татварын хуулиар дамжуулж бүх хөнгөлөлт, чөлөөлөлт, нийгмийн халамжийн асуудлаа шийддэг. Энэ нь татвар төлөгч татварын алба, татвараас зугатаах биш харин өөрөө ирж бүртгүүлэн, тайлангаа гаргаж ирүүлэх механизм болж чадсан байна.
- Аливаа хууль санаачлах, өөрчлөх асуудлыг мэргэжлийн яам, агентлагуудын судалгаа, тооцоонд түшиглэн боловсруулдаг
- Татварын албандаа төсвийн орлогын төлөвлөгөө өгдөггүй боловч татварын ногдуулалтыг сайн хийж, ногдлыг өр болголтгүй хурааж чаддаг. Төсвийн орлогын дутууг СЯ нь бонд гаргах замаар нөхдөг байна.
- Үндэсний татварын алба, ОНутгийн татварын албатай, ҮТАлба нь “Улсын татвар”-ыг хэрэгжүүлдэг
- ҮТА-ны албаны дэргэд Улсын татварын коллеж ажилладаг. Төрийн албаны шалгалтад тэнцсэн 12 жилийн боловсролтой иргэнийг ч татварын ажилтан болгож сургадаг

- Нийт байцаагчдын 70 гаруй хувь нь хяналт шалгалтанд ажилладаг бөгөөд татварын ХШ-ын ажлыг татвар ногдуулалт болон ХШ-ын хэлтсүүд явуулж, шалгалтаар илэрсэн зөрчлийг тайлан засварлах, актаар ногдуулах замаар шийдвэрлэдэг. Электрон арилжааны багийг зохион байгуулсан, Томоохон ААНэгжүүдийн ХШ-ыг “татварын газар”-т хийдэг.
- Мөрдөн байцаалтын хэлтэс ажиллаж байгаа
- Татвар хураалтын байцаагчид нь улсын төсвийн орлого бүрдүүлэхдээ “Албан татвар хураалтын хууль”-д заасны дагуу хөрөнгийг хураах, хөрөнгийн шалгалт хийх өргөн эрхтэй байгаа нь татварын өрийг бууруулахад ихээхэн тустай байна.
- “Утсаар шаардах төв”-ийг татварын газруудад төвлөрүүлэн хийж байна
- Татвар хураалтыг Япон банкиар дамжуулан, “татварын төлбөрийн баримт” ашиглан хийж байна.
- Татвар төлөлтийг 24 цагийн дэлгүүрээр дамжуулан хурааж байгаа
- Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн байгууллага болон Хувь нэгжүүдийн холбоодтой нягт хамтран ажилладаг
- Цахим тайлан ашиглаж байгаа бөгөөд “Нээлттэй кодлох аргачлалд суурилсан цахим гарын үсэг баталгаа”-ны ажлыг хийж байгаа .

**Монгол улсын Татварын албаны бүтэц,
зохион байгуулалт, үйл ажиллагааны ялгаа**

- Үндэсний татварын алба улс, орон нутгийн татварын хуулийн хэрэгжилтийг бүхэлд нь хангуулж, төсвийн орлогод оруулж байна
- Азид хамгийн бага татвартай орны нэг боллоо
- Нийт ажилтнууд дээд боловсролтой, нягтлан бодогч эдийн засагч, хуульч мэргэжилтэй ажилтнууд ажиллаж байгаа боловч хариуцлага сул
- Нийт байцаагчдын 70 орчим хувь нь татвар хураалтад ажиллаж байгаа
- Цахим тайлан хүлээн авч байгаа боловч “цахим гарын үсгийн баталгаа”-г шийдвэрлээгүй байгаа (хууль эрх зүйн орчин бүрдээгүйгээс)
- Татварын газар хэлтсүүд харьцагч татвар төлөгчдөд татварын шалгалт хийдэг бөгөөд Үндэсний татварын ерөнхий газрын татварын хяналт, арга зүйн хэлтэс нь хууль хяналтын байгууллагын хүсэлт болон мэдээллээр “давхар хяналт шалгалт” явуулдаг бөгөөд зөрчил их илэрдэг.

**Япон, Монгол хоёр улсын Татварын ажилтны ёс зүй,
дотоод хяналтын адил талууд**

	Япон улсын татварын алба	Монгол улсын татварын алба
--	--------------------------	----------------------------

Адил тал	<ul style="list-style-type: none"> • Татварын албаны албан хаагчдыг гэмт хэрэг, ёс зүйн зөрчилд орохоос урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах • Татварын байцаагчдын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, буруутай үйлдэлд хариуцлага ногдуулах, зөрчил нь гэмт хэргийн шинжтэй эсэхийг хянаж, гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл хуулийн байгууллагад шилжүүлэх • Зөрчил гарч байгаа шалтгааныг тодруулах, давтан гарахаас сэргийлэх, гэмт хэрэг зөрчлийн нуугдмал байдлыг илрүүлж, засч залруулах
----------	--

Япон, Монгол хоёр улсын Татварын ажилтны ёс зүй, дотоод хяналтын ялгаатай талууд

	Япон улсын татварын алба	Монгол улсын татварын алба
Ялгаатай тал	<ul style="list-style-type: none"> • 1949 онд “дотоод байцаагчийн систем” үүссэн. УТЕГ-ын даргын шууд удирдлагад нийт 120 хүнтэй, үүнээс 62 нь УТЕГ-т ажилладаг. • Гэмт хэргийн шинжтэй зөрчлийг шалгах • Төрийн албан хаагчийн хувийн амьдралдаа гаргаж байгаа зөрчил нь ТАХаагчийн нэр хүндэд харшлаж байна гэж үзэж арга хэмжээ авдаг • Нэр хүндийг ихээхэн эрхэмлэдэг 	<ul style="list-style-type: none"> • Хууль хяналтын байгууллагын хүсэлт болон мэдээллээр “Татварын давхар хяналт шалгалт” хийж байгаа бөгөөд энэ шалгалтаар нилээд хэмжээний татвар дутуу ногдуулсан, зөрчил илэрч байгаа тул ХШАЗХэлтсээс өмнөх шалгалтаар зөрчлийг илрүүлээгүй, ёс зүй зөрчсөн талаар “танилцуулга” ирүүлснийг үндэслэн шалгаж, шалтгааныг тодруулан хариуцлага ногдуулдаг • Хувийн амьдралын зөрчлийг авч үздэггүй

Гурав. Бид одоо ямар түвшинд байна вэ?

ОЛОЛТТОЙ ТАЛУУД

- 1993 оноос татварын багц хууль үйлчилж, татвар төлөгч нь өөрөө орлого, татвараа тодорхойлж төлдөг шинэ тогтолцоог гол зарчмаа болгон хуульчилсан

- Аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллага, төсөвт байгууллага, шашны байгууллагуудын бүртгэлийг регистржүүлж, нэрийн давхардлыг арилгаж байна
- Олон улсын хэмжээнд хамгийн бага татвартай орны нэг болж, татвар төлөгдөх боломжтой байх чиглэлийг тууштай баримтлаж байна
- Татвар төлөгчдөд нэг цэгээс үйлчлэх үйлчилгээг татварын албанд нэвтрүүлээд байна
- Цахим татварын алба болох зорилт тавьж ажилласнаар ААНОАТ-58,6 %, ХХОАТ-61,5%, НӨАТ-80,2 %-д тус тус хүрээд байна
- Татвар төлөгчдийн талаарх хөндлөнгийн мэдээллийн сантай болж, хяналт шалгалтын ажилд ашиглаж байна
- Жил тутам өсөн нэмэгдэж байгаа төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэн ажиллаж байна
- Байцаагчдын боловсролыг байнга дээшлүүлэхийн тулд тасралтгүй сургалт зохион байгуулж байна

БИДНИЙ ДУТАГДАЛТАЙ ТАЛУУД

- Хүнд суртлын индекс буурахгүй байна
- Авилга байна. 2008 онд авилгын хэргээр татварын улсын байцаагч шийтгэгдсэн байна
- Нийслэлийн дүүргүүдийн татварын албадын бүтэц зохион байгуулалт өөр өөр, үүнийгээ туршилтын журмаар гэх боловч аль нь оновчтой хувилбар болох нь тодорхойгүй хэвээр удааширч байгаагаас ажлын ачаалал жигд биш гэсэн мэтгэлцээн тасрахгүй, татвар төлөгчдөө булаацалддаг хэвээр байна.
- Татварын хэлтэс, тасгуудын ажлын уялдаа холбоо шаардлагын түвшинд хүрэхгүй байна ажлын ачаалал жигд биш байгаагаас зарим тасгуудад байцаагчид ажиллах сонирхолгүй байх
- Зарим байцаагчдын мэдлэг, ажлын ур чадвар дутмаг байгаа нь ажилд анх шалгаруулалт хангалтгүй
- Идэвх санаачлага, ажлын хариуцлага сул байна.
- ААН байгуулах явдал сүүлийн жилүүдэд огцом нэмэгдэж, нийслэлийн хэмжээнд ААН-ийн тоо бараг 2 дахин өссөн боловч үйл ажиллагаа явуулдаггүй, хаяг байршилдаа байдаггүй, алдагдалтай ажилладаг ААН-ийн тоо ихэссэн. үйл ажиллагаа явуулдаггүй ААН-үүд татан буугдахгүй гэх боловч татварын тайланг хугацаанд нь ирүүлдэггүй, түүнчлэн тайлан гаргахгүй гэсэн ташаа ойлголт тэдэнд түгээмэл байдаг
- Төрийн албадын хоорондын мэдээлэл солилцох, ажлын уялдаа холбоо муутай
- Ажлын байрны нөхцөл байдал, ажиллагааг урамшуулах механизм хангалтгүй байна. (утасны зардал, шагнал урамшуулал, нийгмийн асуудал)

- Мэдээлэл, ажлын ачаалал ихтэй байгаа өнөөгийн нөхцөлд компьютерийн хангамж, хүрэлцээ, хүчин чадал тааруу байна
- Татвар төлөгчдөд хийх сургалт, байнгын дохио санамж болохуйц сурталчилгаа хангалтгүй байна
- Банкууд татвар төлөгчийн төлсөн татварын баримтыг тухай бүр өгдөггүйгээс тодорхойгүй орлого нэмэгдэж, өр хаагдахгүй, татварын тооцоололд алдаа гаргаж байна.
- Нэг цэгийн байцаагчдын ажлын эцсийн үр дүн болох татварын тооцооллын мэдээлэл алдаатай байх, түүнийг бүрэн хянах механизм дутагдаж байна
- Татвар төлөгчийн хувийн хэргийн баяжилт хийх, хадгалах, ашиглалтад нь хяналт тавих, архивлахад хүн хүч дутагдаж байна
- Цахим тайлан хүлээн авах ажил жинхэнэ утгаар хэрэгжээгүй байна.

Дөрөв.Дүгнэлт. Сайжруулах арга зам.

- Татварын албаны бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох. Татварын байцаагчдын гүйцэтгэх үүргийг тодорхой болгон тоог цөөлж цалин хангамжийг нь нэмэгдүүлэн ,тайлан хүлээн авах болон өрийг нэхэж утсаар ярих зэрэг ажилд түр ажилчин авч ажиллуулах,эсвэл орон тооны бус байцаагчдыг ажиллуулж болох
- Хэлтэс, тасгуудын хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулж, хариуцлагыг өндөржүүлэх, ажлын ачаалал ихтэй тасгийн ажилтнуудад нэмэгдэл урамшил олгох
- Татварын албыг хүнд суртал, ёс зүйн зөрчил, авилга, гэмт хэргээс ангижруулж, олон түмний дунд нэр хүндийг дээшлүүлэхийн тулд үнэнч шудрага ажилтнуудаар бүрдүүлэх, танил тал харж ажилд авахыг бүрэн зогсоох,
- Татварын албанд шинээр ажилтан авахдаа нягтлан бодох бүртгэл, татварын хуулийн мэдлэг, түүнийгээ ажилдаа ашиглах дадлага, бусдад хуулиа сурталчилж ойлгуулах, багаар ажиллах, хэрэглээний болон бусад программд ажиллах, бие дааж асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэх чадвар, шударга байдал, үүрэг хариуцлага, ёс зүйг ухамсарладаг байдлыг гол үзүүлэлт болгож сонголтоор авах, ингэхийн тулд дахин сургах байгууллагатай болох.
- Иргэд хуулиар хориглоогүй үйл ажиллагааг явуулж орлого олох боломжтой тул “Хуулийн этгээд”-ийг бүртгэх босгыг өндөрсгөж, Улсын тэмдэгтэй хураамжийг нэмэгдүүлэх, бүртгүүлсэн хугацаандаа үйл ажиллагаа явуулаагүй болон хаяг байршилдаа байдаггүй ААНБ-ыг олж ирүүлэх, татан буулгахад татварын албатай хамтарч ажиллах үүрэг хүлээдэг байхаар хуульд нэмэлт оруулах
- Хуулийн этгээд, ашгийн бус байгууллага байгуулж байгаа иргэдийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх (орлого, татвараа хугацаанд нь тодорхойлж тайлагнах, ногдлыг тухай бүрд нь төлөх, үйл ажиллагаа явуулаагүй орлого олоогүй бол “Чагтан” тайлан гаргаж, албан бичгээр шалтгаанаа бичиж хавсарган ирүүлэх, гэрчилгээнд нэмэлт өөрчлөлтөө хийлгэж байх гэх мэт) явдлыг хэвшүүлэх,урьдчилгаа татвар төлүүлдэг болгохоор ,хуульд нэмэлт өөрчлөлт оруулах.
- Татвар төлөгчдөд “татварын тайлангаа хугацаанд нь гаргаж тушаах, татвараа төлөх, бусад үүргүүдээ биелүүлэх” талаар санамж болох сурталчилгааг өглөөнөөс эхлээд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр бизнесийн мэдээллийн цагаар байнга өгч байх, ирээдүйн татвар төлөгчдөд хүүхэд байхаас нь хичээлийн программд нь оруулах зэргээр татварын тухай ойлголтыг ухамсарт нь суулгах ажлыг оновчтой хэлбэрээр тасралтгүй хийх
- Банкуудын татвар төлөгчдийн татварт төлсөн мөнгөний төлбөрийн баримтыг тухай бүрд нь татварын албанд ирүүлж ажилладаг болгох

талаар шаардах, дутагдал, зөрчлийг таслан зогсоохын тулд арилжааны банкны тухай хуульд нэмэлт оруулах

- Төрийн албадын хоорондын уялдаа холбоог сайжруулж, татварын албыг төрийн сангийн шилэн кабельд холбож, олгосон зөвшөөрөл, тендер, ажлын гүйцэтгэл, төлбөрийн мэдээллийг цаг алдалгүй татварын албанд авч ажиллах.